



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 02 сарын 11 өдөр

Дугаар А/150

Булган сум

Г Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах Г
орон тооны бус салбар зөвлөлийг
шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.4, 42 дугаар зүйлийн 42.1.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны “Журам шинэчлэн баталж, тогтоолын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 402 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай болон бусад холбогдох хууль, тогтоомжийн хэрэгжилтийг орон нутагт хангуулах, салбар дундын хамтын ажиллагааг уялдуулан, нэгдсэн удирдлагаар хангах чиг үүрэг бүхий “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус салбар зөвлөл”-ийн бүрэлдэхүүнийг шинэчлэн, хавсралтаар баталсугай.

2.Зөвлөлийн дүрмээр хүлээсэн эрх, үүргийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалахад чиглэсэн хууль, тогтоомж, төрөөс баримтлах бодлого, шийдвэрийг орон нутагт хэрэгжүүлэн, төр, төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг бэхжүүлж, салбар хоорондын уялдаа холбоог хангаж ажиллахыг салбар зөвлөлийн нийт гишүүдэд үүрэг болгосугай.

3.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус салбар зөвлөлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсөвт тусган, төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж, зохион байгуулсан ажлын тайланг тухай бүрд нь салбар зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (М.Батчимэг)-д үүрэг болгосугай.

4.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2023 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн А/644 дүгээр захирамжийг хүчингүйд тооцсугай.


ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



03

Аймгийн Засаг даргын 2025 оны
дугаар сарын 11-ны/ний өдрийн А/150 дүгээр
захирамжийн хавсралт



ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙГ ХАНГАХ
ОРОН ТООНЫ БУС САЛБАР ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга:

Аймгийн Засаг дарга

Гишүүд:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын
хэлтсийн дарга

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн
сангийн хэлтсийн дарга

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн
хэлтсийн дарга

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого,
төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга

Эрүүл мэндийн газрын дарга

Боловсролын газрын дарга

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга

Нийгмийн даатгалын газрын дарга

Насан туршийн боловсролын төвийн захирал

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Хөгжлийн
бэрхшээлтэй хүний асуудал хариуцсан мэргэжилтэн

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн "Оргил-Мээж" ТББ-ын
тэргүүн (зөвшилцсөнөөр)

Монголын Хараагүйчүүдийн үндэсний холбооны Булган
аймаг дахь салбар зөвлөлийн гишүүн (зөвшилцсөнөөр)

Тэргэнцэртэй иргэдийн холбооны гишүүн (зөвшилцсөнөөр)

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эхийн холбооны
гишүүн (зөвшилцсөнөөр)

Нарийн бичгийн дарга:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын
хэлтсийн Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын бодлого
хариуцсан мэргэжилтэн